



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/148

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г" дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр "Их тойруу 8-817" тоотод байршилтай Нямзавын Баярмөнх (ЗК77121610)-ийн худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 1200 м.кв (0.12 га) газрыг Балжиннямын Ширчмаа (ЗК84090201)-д зориулалтын дагуу шилжүүлэн 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/148 дугаар захирамж мөн газар эзэмших эрхийн 000116683 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ